**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 05 №01/09. Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Татварын хэлтсийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийх явцад албан хаагчдын цалингийн шатлал ахиулан 1,261,115.00 */нэг сая хоёр зуун жаран нэгэн мянга нэг зуун арван тав/* төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоолын 4-т */төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах .../*, 5-д */төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах/* заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д */Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрхзүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т */Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.7-д */Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/* заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлалыг хуучин хэвээр олгох;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг төсвийн шууд захирагч М.Туяацэцэг, нягтлан бодогч Н.Долгорсүрэн нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:**

АУДИТОР Ж.УГТАХБАЯР

**ЗӨВШӨӨРСӨН:**

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ М.ТУЯАЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ Н.ДОЛГОРСҮРЭН

---

[1] *Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/*